



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/143


Батширээт сум

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.12, Засгийн газрын 2015 оны 286 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын даргын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 27 тоот албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үүрэг бүхий Шуурхай штабыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс байгуулсугай.
2. Шуурхай штабын ажиллах удирдамжийг нэгдүгээр, бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Үүссэн нөхцөл байдлын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг сумын Онцгой комиссын нарийн бичгийн дарга (Д.Бүдханд)-д үүрэг болгосугай.
4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Төрмөнх)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501179